

MED-62 MED-63



Caring for everyone



Цусны даралтыг хэмжих механик багаж

MN Хэрэглэх заавар

1. УДИРТГАЛ

Механик цусны даралт хэмжих багаж нь цусны даралт хэмжих стандарт багаж юм. Цусны даралт хэмжих багаж нь хэрэглэхэд хялбар ба онговчтой хэмжилтийг гүйцэтгэдэг. Механик цусны даралт хэмжих багажийг эмнэлэг болон гэрийн нөхцөлд өргөн хэрэглэдэг.

2. ЗОРИУЛАЛТ

Цусны даралтыг хэмжих механик багаж нь систолын болон диастолын цусны даралтын шууд бус хэмжилтийг хийхэд зориулагдсан.

3. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

- Энэхүү багажийг зөвхөн энэ гарын авлагад заасны дагуу ашиглах ёстой.
- Бүрүү ашигласнаас үүсэх гэмтэлд үйлдвэрлэгч хариуцлага хүлээхгүй.
- Багажийг цохилтоос хамгаална уу.
- Хэзээ ч ханцуйвчийг 300 мм рт. ст.-с дээш заалтад хүртэл шахаж болохгүй.
- Багажны резинэн хэсэгт хурц эсвэл зүсэгч зүйлсээр гэмтэл учруулж болохгүй.
- Багажийг хэт их эсвэл хэт бага хэмийн нөлөөнд байлгаж болохгүй. Багажны ханцуйвчтай их болгоомжтой харьцах хэрэгтэй.
- Багажийг хүүхдүүд хяналтгүй ашиглахаас сэргэмжлээрэй; багаж нь жижиг хэсгүүдийг агуулдаг.

4. ХОРИГЛОХ ЗААЛТ:

Хориглох заалт: Илрээгүй. Өөрийн эмчтэй зөвлөлдөөрэй.

5. ЦУСНЫ ДАРАЛТЫН ЗААЛТЫН АНГИЛАЛ

Цусны даралтын заалтын хүснэгт (мм рт. ст.-р хэмжсэн) нь Европын гипертензийн нийгэмлэгийн ангилалтай нийцж байна.

Цусны даралтын заалтын хүрээ	Систолын даралт	Диастолын даралт	Арга хэмжээ
3 дугаар түвшин: хүчтэй гипертенз	180-с дээш болон тэнцүү	110-с дээш болон тэнцүү	Яаралтай эмчид хандана уу!
2 дугаар түвшин: дунд зэргийн гипертенз	160-179	100-109	Эмчид хандана уу
1 дугаар түвшин: хөнгөн гипертенз	140-159	90-99	Эмчийн зөвлөгөө
Өндөр хэвийн	130-139	85-89	Эмчийн зөвлөгөө
Хэвийн	130-с доош	85-с доош	Бие даасан хяналт
Оновчтой	120-с доош	80-с доош	Бие даасан хяналт

① **Тайлбар:** Хэмжилтийн заалтыг эмчдээ үзүүлнэ үү. Эмчийн бичиж өгсөн эмийн түнг өөрийн хэмжилтийн үр дүнгээс хамааран хэзээ ч дур мэдэн өөрчилж болохгүй.

6. БАГАЖНЫ БҮРДЭЛ ХЭСГҮҮД MED-62, MED-63

ЗАГВАР MED-63

Чагнуурын толгойг ханцуйвчинд суурилуулсан



7. УГСРАЛТЫН ЗААВАР

Зурагт үзүүлсэн шахагч ба даралт хэмжигчийг манжетнээс гарсан хоёр гүүрсэд холбон. MED-62 / MED-63 загвар: Чагнуурыг угсрахдаа чагнуурын толгойг Y-хоолойн дан гүүрсэн төгсгөлд холбон (MED-63 загварын хувьд чагнуурын толгой нь манжетдаа байдаг). Y-хоолойн хос гүүрсэн төгсгөлд чагнуурын металл чихний хоолойг холбон.

① **Тайлбар:** Хэрэв хэмжүүрийн заагч нь "□" -ээр илтгэсэн голлосон тэг цэгт байхгүй бол даралт хэмжигч гэмтэлгүй байна. Даралт хэмжигчийн заагч нь тэг цэгийн дотор байх ёстой ба үйлдвэрлэгч нь шаардлагатай нарийвчлалыг гаргах байрлалд тохируулсан байдаг.

Түлхүүрийг ашиглан заагчийг тэг цэгт тохируулна уу. Түлхүүрийг даралт хэмжигчийн ёроолд байгаа дугуй нүхэнд оруулаад түлхүүрийг эргүүлэхэд заагч хөдөлнө. Төхөөрөмжийг ашиглахад бэлэн байна.

8. ХЭМЖИХ ҮЙЛ ЯВЦ

1. Өвчтөн сандал налан сууж хөлийг шалан дээр тэгш тавьж гарыг зүрхний түвшинд байрлуулна.

△ **БОЛГООМЖТОЙ:** Багажны бүх бүрдэл хэсэг найдвартай, зөв угсрагдсан эсэхийг шалгаарай. Зохих ёсны дагуу угсрагдаагүй багаж нь алдаатай үр дүнг заах эсвэл гэмтэлд хүргэх аюултай.


2. Гарны дотоод гадаргуун дээр тохойн нугалмаас 2 см дээш хоёр хурууг байрлуулсан мөрний судсыг олно.

3. Ханцуйвчийн доод ирмэг тохой нугалмаас 2 см дээш байрласан байхаар ханцуйвчийг гарт зүүнэ.

4. Ханцуйвч нь гарт сайн наалдсан байх ёстой. Дэгээ бүхий оёсон материалтай чөлөөтэй төгсгөлийг ханцуйвч дээрх наалдах материалаас хийсэн хэсэгт барьж ханцуйвчийг тогтооно. Шаардлагатай тохиолдолд ханцуйвчийн байрлалыг засна.

5. Өвчтөний гарыг ширээн дээр тавина. Гарыг сулласан байх ба алгыг дээш харуулна. Ханцуйвч нь зүрхний түвшинд байрласан байх ёстой.

6. Циферблат таны нүдний өмнө байрласан байхаар даралт хэмжигчийг нэг гартаа барина. Нөгөө гартаа шахагчийг барина.



Агаарыг шахагчийг гарган хавхлагыг хааж цагийн зүүний дагуу эргүүлнэ.
7. Ханцуйвчийг шахахын тулд шахагчийг хурдан атгана. Даралт хэмжигч заалт дээр хүртэл ханцуйвчийг шахна. Мөнгөн усны багана дээр 20-30 мм-р ХЭТЭРСЭН ХЭВИЙН систолын даралт.

△ **АНХААРНА УУ:** ханцуйвчийг 280 мм рт. ст.-с хэтэрсэн заалт хүртэл шахаж болохгүй. Учир нь өвчтөнд гэмтэл учруулах эсвэл багажийг эвдэх магадлалтай.

8. Агаар гаргагч хавхлагыг цагийн зүүний эсрэг зүгт эргүүлэн удаанаар нээгнэ. Агаарыг мөнгөн усны баганад 2-4 мм/секунд байхаар хурдтай гаргана.

9. Дуу чимээ гарч байгаа эсэхэд анхаарч даралт хэмжигчийг ажиглаарай. Дуу чимээ сонссон даруйдаа даралт хэмжигч дээрх заалтыг тогтоож аваарай. Энэ заалт нь өвчтөний СИСТОЛЫН даралтын үзүүлэлт байх болно.

10. Ханцуйвчнаас агаарыг 2-4 мм рт.ст. хурдтайгаар гаргасаар байна. Дуу чимээ гарахаа бүрэн болих хүртэл даралт хэмжигч дээрх даралтын заалтыг тогтоож аваарай. Энэ нь өвчтөний ДИАСТОЛИЙН даралт байх болно.

11. Үлдсэн агаарыг гаргахын тулд цагийн зүүний эсрэг зүгт эргүүлж хавхлагыг бүрэн салгана. Үзүүлэлтийг бичиж авна.

① **Тайлбар:** Хэрвээ та өвчтөний даралтыг давтан хэмжилтийг хийхийг хүсвэл ханцуйвчийг дахин хоёр удаа шахаж болно. Давтан хэмжилтийг эхлэхийн өмнө 2-3 минут хүлээж шахагдсан судаснаас шалтгаалан онговгүй үзүүлэлт гарахаас сэргийлнэ.

Товч гарын авлага

Хэмжихийн өмнө

1. Хэмжилт хийхийн өмнө 5 минутаас багагүй хугацааны туршид амарна.
2. Гарыг их барьсан хувцсаа тайлах хэрэгтэй. Ханцуйгаа шамлах хэрэггүй. Учир нь энэ нь таны гарыг дарах ба хэмжилтийг онговгүй болгоно.
3. Хэмжилт хийхээс өмнө 30 минутаас багагүй хугацаанд хоол идэх, тамхи татах, дасгал хийж болохгүй.

Хэмжилт хийх үед

1. Ханцуйвчинд агаарын хоолой орох товч нь тохойн хонхрын дээр, зүрхний түвшинд байрлаж байх ёстой.
2. Чагнуурын толгой мөрний гол судсан дээр байрлуулна.
3. Ханцуйвчийг шаардлагатай гэмтэл хүртэл шахна (даралт хэмжигч дээр гарах даралт ойролцоогоор 20-30 мм рт. ст. байх ба тооцоолсон систолын даралтаас дээш байна).
4. Хэмжилт хийх явцад хөдлөхгүй, ярихгүй байхыг хичээгээрэй.
5. Ханцуйвчнаас агаарыг удаанаар гаргах ба даралт секундэд 2-3 мм рт. ст. хурдтайгаар буурах ёстой.

Хэмжилтийн дараа

1. Давтан хэмжилт хийхийн өмнө 2-3 минут хүлээнэ.

9. ЦЭВЭРЛЭГЭЭ БА АРЧИЛГАА

- Багажийг гэмтлээс хамгаалах үүднээс ханцуйвчийг угааж БОЛОХГҮЙ ба норхоос сэргийлэх, мөн унагахаас зайлсхийнэ үү.
- Багажийг хоёр жилд нэгээс багагүй удаа шалгаж байна. Хэрвээ багаж нь онцлох үзүүлэлтэд зааснаас үүрч алдаа гаргаж байвал багажийг дахин тохируулах хэрэгтэй.
- Багажийг цэвэрлэхийн тулд түүнийг цэвэр зөөлөн алчуураар арчина.
- Багажийг аливаа шингэнд живүүлэхийг хориглоно.
- Багажид халуун ариутгал хийхийг хориглоно.

Ханцуйвчнаас агаарыг бүрэн гаргасны дараа даралт хэмжигчийн зүү зөвшөөрөгдсөн алданы бүсэд зогссон байх ёстой. Хэрвээ агаарыг ханцуйвчнаас бүрэн гаргасан байхад зүү зөвшөөрөгдсөн алданы бүсээс гарсан байвал даралт хэмжигчийн үзүүлэлт онговчтой биш байна. Энэ тохиолдолд багажийг өөрт ойр үйлчилгээний төвд хүргэж тохируулга (баталгааны хуудсан дээр үйлчилгээний төвүүдийн хаягийг заасан болно) хийлгэнэ.


10. ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

Хэмжилтийн алхам: 2 мм мөнгөн усны багана
Хэмжилтийн хүрээ: 0-300 мм мөнгөн усны багана
Оновчтой байдал: ±3 мм мөнгөн усны багана
Ашиглах нөхцөл: 0°C-с +40°C хүртэл, чийгшил 15%-с 85% хүртэл
Хадгалах нөхцөл: -5°C-с +40°C хүртэл, чийгшил 15%-с 85% хүртэл
Барьсан EN ISO 81060-1/2 Стандарт

11. БАТАЛГААНЫ ҮҮРГҮҮД

Үйлдвэрлэгч нь баталгааны үүргээ багажийг худалдан авсан өдрөөс эхлэн 2 жилийн туршид хангана. Ханцуйвчны баталгаа – 1 жил. Багажийг бүрүү ашигласнаас үүдсэн гажиг болон хайрцагт баталгаа хамаарахгүй. Хэрвээ баталгаат хугацаанд үйлдвэрийн гэмтэл илэрсэн бол эвдрэлтэй багажийг засварлана. Засварлах боломжгүй тохиолдолд шинээр солино.
Үйлдвэрлэлийн шаардлагын дагуу урьдчилан мэдэгдэлгүйгээр бүтээгдэхүүнд бутан болон хэсэгчилсэн өөрчлөлтийг хийх эрхийг үйлдвэрлэгч эдэлнэ. Үйлдвэрлэсэн огноог даралт хэмжигч дээр серийн дугаараар заасан байна: сарын дугаар, дараа нь оны сүүлийн тоонууд.

12. ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ УТГА



Сүүлчийн хувилбар 2022-W08

B.Well Swiss AG
Bahnhofstrasse 24, 9443 Widnau, Switzerland · www.bwell-swiss.ch